

“Дөрвөн дэлбээт цэцэг”-ийн дүрслэл дэх Мандала бүтэц (Археологийн олдворын жишээн дээр)

Тогтохбаярын Эрдэнэтуяа 

Чингис хаан үндэсний музей, Улаанбаатар, Монгол Улс

✉ tuyartist@gmail.com

Хураангуй: “Дөрвөн дэлбээт цэцэг” нь дэлхий даяар олон соёлд тархсан өвөрмөц дүрслэл бөгөөд тухайн соёлоос хамаарч янз бүрийн бэлгэдлийн утгаар илэрч байдаг. Утга, бэлгэдлийн хувьд ерөнхий хэд хэдэн категорид хамааруулах боломжтой. Монгол нутагт мөн адил өөрийн гэсэн онцлог тусгалаа олж эрт үеэс соёл, урлагийн бэлгэдэлт тэмдэг, дүрс болон ирсэн бөгөөд археологийн дурсгалаас жишээ болгон авч үзэв. Энэхүү дүрслэл нь эрт үеийн анхдагч дүрсийн хэллэгийг агуулсан бөгөөд орчин үеийн имитаци бүхий дүрс болон хээнээс ялгагдаж буйг дурдах хэрэгтэй. Эх үүтгэл дүрсүүд ихэвчлэн сэтгэцийн дотоод бүрдлээс эх авч илрэх боломжтой байдаг талаар судалгаа нотолж байна. Дүрслэх урлагийн хэллэгт огтолсон тэнхлэг болох босоо болон хэвтээ шулуун дээр зохиомжийн дүрслэл хийгддэг.

Энэхүү тэнхлэгт зохируулан тэгш хэмийн хуваагдлаар үүсэх анхдагч дүрслэл нь дөрвөн дэлбээт цэцэг бөгөөд энэ нь Мандала бүтцийн дүрслэлтэй холбогдоно. Дүрсийн эх болох дугуй дүрснээс дөрвөн дэлбээт цэцэг үүсэх ба дугуй дүрс, төв цэг, тэгш хэмт тэнхлэг нь сэтгэцэд таатай мэдрэмж төрүүлж гоо зүйн ойлголтыг өдөөж байдаг. Бидний тархинд байгалиас заяасан төрмөл чадвар болох тэгш хэмт дүрсийг таашааж улмаар оксодицин дааврыг ялгаруулахад нөлөөлдгөөрөө, сэтгэцийн бүтэцтэй (ухамсар болон ухамсаргүйн түвшин) далд байдлаар холбогдож байгаа бөгөөд эдгээр эх дүрсийг тодруулан, гоо зүйн хэллэг бүхий судалгааг хийв.

Түлхүүр үгс: *сэтгэц, хамтын ухамсаргүй, Мандала, эх тэнхлэг, дугуй*

The Mandala Structure in the Representation of the “Four-petaled flower” (Based on the example of an archaeological find)

Erdenetuya Togtokhbayar 

“Chingis Khaan” National Museum, Ulaanbaatar, Mongolia

✉ tuyartist@gmail.com

Abstract: The “Four-petaled flower” is an unique representation spread across worldwide, exhibiting various symbolic meanings depending on the characteristics of those cultures, categorized into several general groups. In Mongolia, it has similarly found its own distinctive expression, becoming an element of culture and art from ancient times, and several archaeological and cultural heritage sites serve as examples. This representation contains the expression of an ancient, primary image, and it should be noted that it differs from modern imitative images and patterns. Research confirms that original images often originate from the internal components of the psyche. In the language of visual art, compositional representation is done on intersecting axes, namely vertical and horizontal straight lines. The primary representation formed by symmetrical division according to this axis is the four-petaled flower, which is connected to the representation of the Mandala structure. These originate from the circular image, which is the source of the image, with the four-petaled flower arising from it. The circular image, the central point, and symmetry create a pleasant sensation in the psyche and aesthetic understanding, which is connected to the mental structure due to the innate appreciation of symmetrical images releasing oxytocin, and these original images were analyzed by clarifying their aesthetic expression.

Keywords: *mind, collective unconscious, primary axis (central axis), circular form*

Оршил

Тухайн угсаатны соёлын онцлог бүхий илрэлтэй бэлгэдэлт дүрс, тэмдэг, хээ нь хэллэгийн хэм хэмжээгээрээ болон тэдгээрийг үүсгэгч эх үүтгэл дүрсүүдээрээ ялгагдах чухал шинжийг агуулдаг. Аливаа соёлын холбоосууд өөрсдийн онцлогоос хамаарч бэлгэдэлт дүрсийг үүсгэдэг боловч бэлгэдлүүд нь тархины бүтцийн сэтгэцийн талуудаас эх авч үргэлжлэн удамших шинж чанартай. Иймээс эдгээрт бүрэн тодорхойлж эсвэл тайлбарлаж болохгүй илүү гүн ухамсаргүй талууд зонхилох бөгөөд энэхүү төрөлхийн шинж чанараас шалтгаалан хэв маягуудыг таньж, тайлбарладаг (Whitehand 2009, 13).

Хүн төрөлхтний хамтын ухамсаргүйгээс (collective unconscious) үүтгэгдсэн эх дүрс болон суурь ойлголтын анхдагч хэлбэр бүхий урлагийн ухамсаргүй агуулга дахь (Jung 1964, 35) хувь хүний дотоод зөрчилдөөнийг шийдвэрлэхэд урлагийн дүрслэлийн хэл хувь нэмэр оруулдаг. Аливаа судлаач нь өнөөгийн нөхцөл байдлаар дүгнэх нь судалгааны баримтыг эдүгээчлэн сэтгэх алдаанд хүргэдэг бөгөөд бид одоогийн техникжсэн, логик ухааныг урдаа барьсан онцлог бүхий өнөө үеийн байдлаас нэг алхам ухраад яг тухайн үеийн нөхцөл байдал бүхий хүн төрөлхтний сэтгэхүйгээр харахыг зөвлөсөн байдгийг санууштай.

Дөрвөн дэлбээт цэцгийн дүрслэл нь (зөвхөн олдворын хувьд шинжилж буй боловч дөрвөн тэнхлэгээс бүтсэн ямар ч дүрс байх боломжтой) дөрвөн тэнхлэг бүхий сэтгэлгээний цар хүрээ, давтагдсан чанар дахь геометрийн хэллэг гээд урлагийн сэтгэл зүйн онцлогийг агуулдаг. Аливаа анхдагч хээ, дүрс нь өнгөц гоёл шиг харагдах төдийхнөөр хязгаарлагдахгүй, одоо цаг үед үйлдвэржсэн, гоёмсог, гангалах, имитаци бус үүсэл гарвал нь өөрөөсөө үүтгэгдсэн онцлогтой, аливааг санаанаасаа зохиож үйлддэггүй байсан гэх эрт үеийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй бөгөөд шашин болон урлагт эдгээр дүрслэл нь үргэлж оршин байдгийг онцлууштай.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны бүтээлд өнгө, шугам, хэлбэр, бүтэц, найруулга, хэмжээг сайтар ажиглах болон дөрвөн дэлбээт цэцгийн бүрдүүлбэр элементүүд хоорондоо шугамын динамик, хэлбэрийн тэгш хэмийн гэх мэтээр үндсэн бүтэц, зохион байгуулалтыг илрүүлэх зорилготой формализмын арга зүйг ашиглав. Мөн хэлбэрийн элементүүд болон тэдгээрийн харилцаа нь бүтээлд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрүүлж байгааг тайлбарлах болон хэлбэрийн төгс байдал, зохицол, шинэлэг байдлыг үндэслэн гоо зүйн үнэ цэнийг үнэлэх зэргээр хэрэглэв. Иконограф болон иконологийн арга зүйгээр сэдэв, бэлгэдлийг хооронд нь холбож, тэдгээрийн харилцааг судлав. Соёлын контекстийг харгалзан үзэж урлагийн бүтээл тухайн үеийн нийгэм соёлын байдалд хэрхэн тусгалаа олсон зэргийг шинжлэн тухайн урлагийн бүтээлийн бүтээгдэх зорилго гоо зүйн хэллэгийн үндсийг тодруулах зэргийг оролдов. Аналитик онолыг сэтгэц дахь бүтцийг хэрхэн урлагт нөлөөлж болох талаар, мөн семиотик арга зүйгээр дүрс, дохио, тэмдэг, зан үйл, объект зэрэг бүхий л төрлийн “текст”-ийг судалж, тэдгээрийн дотоод бүтэц, харилцаа холбоо, соёлын контекст дэх утга учрыг задлан шинжлэхэд чиглүүлж, бэлгэдэл утгыг задлан шинжлэх зорилгоор ашиглав. Урлагийн сэтгэл зүйн арга зүйгээр гүний сэтгэл зүйн онолыг ашиглан задлан шүүмжлэлийг хийж сэтгэцийн нарийн процессыг тодруулав.

Судалгааны үр дүн

Хээ нь зөвхөн гоёл чимэглэлийн үүргээр хязгаарлагдахгүй, гүн гүнзгий утга учир агуулсан соёлын үзэгдэл юм. Хээ нь тухайн үндэстний түүх, зан заншил, ертөнцийг үзэх үзлийг илэрхийлдэг бэлгэдэл. Үеэс үед дамжиж ирсэн соёлын өв бөгөөд тухайн үндэстний түүх, зан заншил, ертөнцийг үзэх үзэл агуулагддаг (Нямбуу 1998, 28). Тодорхой соёлын онцлогоос хамаарч утга учир агуулсан бэлгэдлээр илэрч аз жаргал, эрүүл мэнд, хүч чадал гэх мэт утгыг илэрхийлдэг. Дөрвөн дэлбээт цэцгийн хувьд аз завшаан, хөгжил цэцэглэлт эсвэл зүгээр л байгалийн гоо үзэсгэлэнг төлөөлж болно. Мөн эдгээр бэлгэдлийн чанарыг агуулж гоёл чимэглэлийн зориулалтаар ашиглагдаж, хувцас, эд зүйлс, барилга байгууламжийг чимэглэж, илүү үзэмжтэй болгодгоороо урлагийн нэг хэлбэр болох бөгөөд урлагийн өндөр түвшний чадвар шаарддаг. Анхдагч хээний бүтэц нь сэтгэцийн “хамтын ухамсаргүй”-ээс гарсан эх дүрс бөгөөд Дөрвөн дэлбээт цэцэг нь дэлхий даяар ардын урлагийн уламжлалд түгээмэл хэрэглэгддэг. Ихэвчлэн нэхмэл эдлэл, ваар сав болон бусад гоёл чимэглэлийн зүйлсэд дүрслэгдсэн байдаг.

Дугуй дүрсийн хэлэмж. Дөрвөн дэлбээт цэцгийн нэгэн бүрдүүлбэр нь дугуй дүрсийн хэлэмж бөгөөд эргэлэг, эрчимлэг хэлбэр бүхий (Дулам 2011, 27) агуулгыг шингээдэг.

Сэтгэцийн элемент болох анхдагч дугуй дүрсийг координатын босоо болон ташуу зураасаар холбосноор “ухамсарт Мандала”-г бүтээх үндэс нь болдог. Энэ нь Дөрвөн дэлбээт цэцгийн дүрслэмжтэй холбогддог. Дугуй дүрс нь Мандалатай маш гүн гүнзгий холбоотой бөгөөд энэ холбоо нь олон соёл, шашин, сэтгэл зүйн судалгааны үндэс суурь болдог. Энэ нь “Бүтэн байдлын бэлгэдэл” болохын хувьд эхлэл төгсгөлгүй, бүрэн бүтэн байдал, төгс төгөлдөр, хязгааргүй байдлыг бэлгэддэг. Мандалагийн дугуй хүрээ нь орчлон ертөнцийн бүх зүйлийг багтаасан, нэгдмэл байдлыг илэрхийлдэг ба мөн түүнчлэн дугуй нь хувь хүний сэтгэцийн бүтэн байдал, өөрийгөө нээх, төлөвших процессыг бэлгэддэг (Jung 1944, 148). Дугуй дүрс нь төв цэгтэй бөгөөд энэ нь төвлөрөл, тогтвортой байдал, тэнцвэрийг илэрхийлдэг. Мандалагийн төв нь бурхан, өөрийн “би”, эсвэл орчлон ертөнцийн гол хүчийг бэлгэддэг байж болно. Дугуй хүрээ нь төвийг хамгаалж, энерги нь гадагшаа тархахаас сэргийлж, дотоод тэнцвэрийг хадгалдаг гэж үздэг. Мөн түүнчлэн мөнхийн эргэлт, дахин төрөлт, цаг хугацааны мөчлөгийг бэлгэддэг бөгөөд дугуй хэлбэр нь орчлон ертөнцийн мөнхийн хөдөлгөөн, үргэлжлэлийг илэрхийлдэг. Бурханы шашинд Мандала нь сансрын мөчлөг, амьдралын дугуйг дүрсэлдэг. Дугуй нь хаалттай хэлбэр тул хамгаалалт, аюулгүй байдлыг бэлгэдэж, Мандалаг ариун газрыг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг. Олон соёлд дугуй нь нар, сар, гариг зэрэг тэнгэрийн эрхэс болон орчлон ертөнцийг төлөөлдөг ба орчлон ертөнцийн төлөөлөл, бурхдын ордон, бясалгалын объект болгон ашигладаг. Мандалагийн үүсэл, хөгжил, янз бүрийн шашны уламжлал дахь утга санааг Юнгийн аналитик сэтгэл зүйд судалдаг бөгөөд Мандала архетип болон хувь хүний сэтгэцийн хөгжилд үзүүлэх нөлөөг тодотгон авч үздэг төдийгүй урлагийн хэлбэр, гоо зүйн онцлог, соёлын харилцан нөлөөлөл, янз бүрийн соёлд өргөн хэрэглэдгээрээ түгээмэл эх дүрс юм.

Дугуй дүрс нь Мандалагийн үндсэн хэлбэр бөгөөд эдгээрийн хоорондын холбоо нь бүтэн байдал, төвлөрөл, мөнхийн эргэлт, хамгаалалт, орчлон ертөнцийн бэлгэдэл зэрэг олон чухал утга санааг агуулдаг.

Төв цэг дэх дүрслэмж. Дөрвөн дэлбээт цэцгэнд “Axis Mundi” буюу “орчлон ертөнцийн тэнхлэг” нь дэлхийг тэнгис, газартай холбодог төв босоо тэнхлэг гэж үздэг мэдлэг бүхий ухагдахуунтай шууд хамааруулах зохимжтой бус ч төв цэг, дөрвөн зүг, бүрэн бүтэн байдал гэх зэрэг нь “Axis Mundi”-гийн утгатай давхцаж Мандалагийн төв цэг нь яг үүнтэй адил үүрэг гүйцэтгэдэг гэж үзэх боломжтой. Төв нь дээд болон доод ертөнц хоорондын холбоосыг бэлгэддэг ба “Axis Mundi” нь орчлон ертөнцийн төв дэх босоо шулуун зураасыг илэрхийлдэг шиг мандалын төв нь бясалгагч өөрийн “би”-ийн төв, эсвэл бурхдын оршихуйн төвийг бэлгэдэх боломжтой. Мөн “Axis Mundi” нь орчлон ертөнцийн дэг журмыг төдийгүй, тэнцвэртэй байдлыг төлөөлдөг гэж үздэг (Jung 1944, 147).

Mircea Eliade “The Sacred and the Profane” болон бусад бүтээлүүдэд “Axis Mundi”-ийн тухай өргөн хүрээнд тайлбарласан байдаг бол Joseph Campbell “The Power of Myth” болон бусад бүтээлүүдэд “Axis Mundi”-г домог зүйн үүднээс авч

үздэг. Харин Carl Jung, “Psychology and Alchemy” болон бусад бүтээлүүдэд “Axis Mundi”-г архетипийн үүднээс тайлбарладаг нь энэхүү төв цэг нь хэрхэн өргөн хүрээг хамарч байгааг харуулж байна.

Мандалагийн төв цэг нь мөн сэтгэцийн болон орчлон ертөнцийн дэг журмыг бий болгох үндэс суурь болдог. Мандалагийн төв нь бүх зүйл эхэлдэг бөгөөд эргээд буцаж ирдэг цэг ба энэ нь бүтээл, устгал, дахин төрөлтийн мөнхийн мөчлөгийг бэлгэддэг (Eliade 1957, 44).

Төв цэг нь Мандалагийн бүх элементүүдээс ялгаатай боловч тэдгээрийг нэгтгэж, бүрэн бүтэн байдлыг бий болгодог гол цөм юм. Мандалаг бясалгалын объект болгон ашиглах үед төв цэг нь анхаарлыг төвлөрүүлэх гол цэг болдог. Юнгийн сэтгэл зүйд Мандалагийн төв нь хувь хүний сэтгэцийн бүрэн байдал, өөрийн “би”-г бэлгэддэг.

Мандаланууд ихэвчлэн хэвтээ болон босоо тэнхлэгүүдийг агуулдаг. Эдгээр тэнхлэг нь Мандалагийн бүтцийг зохион байгуулж, дөрвөн зүг, дөрвөн элемент зэрэг олон утгыг илэрхийлдэг ба тэнхлэгүүдийг энергийн урсгалыг чиглүүлэгч гэж үздэг. Төвөөс цацарч буй энерги тэнхлэгүүдээр дамжин орчлон ертөнцөд тархдаг гэж үзэх ба “Axis Mundi”-ийн харилцаа янз бүрийн шашны уламжлалд хэрхэн илэрхийлэгдэж буй байдал болон Мандалагийн бүтцэд тэнхлэг болон төв цэгийн гүйцэтгэх үүргийг хэрхэн ашигладаг, төв цэг болон тэнхлэгүүдийг хэрхэн бэлгэддэг нь сонирхолтой.

Тэнхлэг, ялангуяа төв цэг нь Мандалагийн үндсэн элементүүдийн нэг бөгөөд орчлон ертөнцийн төв, холболт, бүтэн байдал, бясалгалын гол цэг зэрэг олон чухал утгыг агуулдаг.

Тэнхлэгийн тэгш хэм дэх байдал. Дөрвөн дэлбээт цэцэг нь анхдагч тэнхлэг болох босоо тэнхлэг түүн дээр дүрслэгдэх хэвтээ тэнхлэгээс бүтэх бөгөөд эдгээр нь монгол Туухай тамгын дүрслэмжтэй адилсдаг. Босоо болон хэвтээ тэнхлэгт дүрс нь монгол нүүдэлчдийн дунд Туухай хэмээн эртнээс нэрлэгдэж байсан ба Дан туухай тамга нь Биндэрийн Рашаан хадны том хадан самбар, Зорголын Агуйт, Өмнөговийн Далан уулын Үзүүр бичигт, Их бичигт, Ховдийн Дарвийн байшин үзүүрийн Цагаан толгойн хадны зурагт тус тус бий (Дулам 2011, 111) хэмээн тэмдэглэжээ.

Дөрвөн дэлбээт цэцгийн нэг хувилбар болох дөрвөн навчит хошоонгор нь барууны соёлд аз завшааны танил бэлгэдэл юм. Тухайн соёлын онцлогоос хамаарч тэнхлэг бүхий загалмайг ч мөн адил дүрслэх бөгөөд дөрвөн мөчиртэй загалмайг дөрвөн зүг болон сүнслэг болон материаллаг ертөнцийн огтлолцлыг бэлгэдсэн гэж үзэж болно. Хэдийгээр үргэлж цэцгийн дэлбээтэй байдаггүй ч мандалын дугуй хэлбэр нь дөрвөн зүгийн цэгтэй төстэй бэлгэдлийн утгыг агуулдаг (McElroy 2020, 36).

Дөрвөн дэлбээт цэцэг нь түүхийн туршид олон соёлд, урлагт маштүгээмэл хээ угалз юм. Энэ нь олон янзын бэлгэдлийн утгыг агуулдаг бөгөөд ихэвчлэн дөрвөн зүгийг бэлгэддэг ба дөрвөн зүг (хойд, өмнөд, зүүн, баруун) эсвэл дөрвөн сонгодог элементийг (газар, агаар, гал, ус) төлөөлдөг. Орчлон ертөнц болон байгалийн ертөнцтэй ийм холбоотой байх нь энэхүү цэцэгт бүрэн бүтэн байдал, тэнцвэрийн мэдрэмжийг өгдөг. Мөн Дөрвөн дэлбээт цэцэг нь амьдралын бүрэн дүүрэн

байдал, түүний бүх талыг хамарч байгааг бэлгэдэж болно. Энэ нь гоо үзэсгэлэн, эв найрамдал, бүх зүйлсийн харилцан холбоог төлөөлдөг бөгөөд дэлбээний төвд нэгдэх нь эв нэгдэл, зохицол, олон янзын элементүүдийн нэгдлийг бэлгэдэж болно. Зарим соёлд дөрвөн дэлбээт цэцэг нь тодорхой тэнгэрлэг эсвэл сүнслэг ойлголтуудтай холбоотой байж болно. Мезоамерикийн зарим соёлд энэ нь нарны бурхан болон байгалийн мөчлөгтэй холбоотой байх ба “Quincunx” буюу дөрвөн дэлбээт цэцэг нь Мезоамерикийн урлагт чухал бэлгэдэл байсан бөгөөд дөрвөн зүг, дөрвөн элемент, орчлон ертөнцийн төвийг төлөөлдөг. Мөн Xicalcoliuhqui хэмээх хээ нь эсрэг тэсрэг бүхий хоёр талт байдлыг төлөөлдөг шаталсан хээ боловч дөрвөн дэлбээт цэцэгтэй адилаар тэнхлэгт хуваагдаж болно. Malinalli нь тэнгэрийн гал болон усны урсгалыг бэлгэддэг хоёр мушгирсан мөчир бүхий нь мөн адил бүтэцтэй ба амьдралын эх



Зураг 1. Quincunx, МЭӨ 211-200, Ром.

үүсвэр болон дөрвөн зүгийг төлөөлж тухайн соёлын онцлог бүхий Ариун уулыг (Пирамид) дүрсэлдэг байна. Бусад соёлд дөрвөн дэлбээт цэцэг нь зарим тохиолдолд сүнслэг ойлголтууд, эсвэл бурхдыг бэлгэдэн шашны урлагт тохиолдож болно. Уран бүтээлчид дөрвөн дэлбээт цэцгийг бүтээлдээ ашиглаж, түүний бэлгэдлийг судалж, шинэ хувилбаруудыг бий болгож баяжуулдаг. Хүннү-гийн урлагт ихэвчлэн амьтны загвар бүхий дүрслэмж (зооморф) байх боловч дээрх бүхий л шинж чанарыг агуулсан дөрвөн дэлбээт цэцгийг соёл болон урлагтаа хэрэглэж, эрхэмлэн дээдэлж байсан нь хорвоог таньсан аугаа их оюунтай байсныг гэрчлэх мэт.



Хүннү - Xiongnu

Зураг 2. Алтан чимэг, Хүннү, Гол мод-20.



Зураг 3. Авсны ханын чимэг, Хүннү, Дуурлиг нарс



Зураг 4. Авсны алтан чимэг, Хүннү

Мандала бүтэцтэй холбогдох нь. Дөрвөн дэлбээт цэцэг нь Мандалагийн үндсэн бүтцийг агуулсан, гүн гүнзгий бэлгэдлийн утгатай дүрс бөгөөд олон соёлд орчлон ертөнц, сэтгэл зүй, шашны ойлголтуудыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Эрт үеийн гоо сайхны таашаал нь сүсэг бишрэлдээ оршиж байсан бөгөөд аливааг гоёчилж загварчлах сэтгэлгээ нь харьцангуй хожуу үеийнх гэхэд болно. Тиймээс хээ бол тэр тусмаа тэгш хэмт тэнхлэгийн дагуу бүтээгдсэн

дөрвөн дэлбээт хээ нь дотоод мөн чанартаа сэтгэцийн толин тусгалыг агуулсан гадаад хэлбэрийн бүрэлдэлт харагдалт юм. Харьцангуй хожуу үеийн хээний загвар нь хээ угалз талдаа болсон бөгөөд чимэглэх, гоёх утга илүү давамгайлж имитаци байдлыг үүсгэх болсноороо эх үүтгэл дүрснээс ялгагдаж байна. Ийнхүү Xicalcolihqui хээ нь эсрэг хүчний хоёр талт байдлыг төлөөлдөг боловч дөрвөн дэлбээт цэцэгний бэлгэдэлтэй холбоотой байх нь орчлон ертөнцийн бүрэн бүтэн байдал, тэнцвэр, бүтээлч байдал болон Мандалагийн элемент гэсэн үндсэн утга санаануудтай холбоотой юм (Wagner 2011, 112). Олон соёл иргэншилд дөрөв гэсэн тоо нь чухал бэлгэдэлтэй. Дөрвөн зүг (зүүн, баруун, хойд, урд), дөрвөн үндсэн элемент (газар, ус, агаар, гал) зэрэг нь орчлон ертөнцийн бүрэн бүтэн байдлыг илэрхийлдэг нь Мандалагийн гол чанар юм. Дөрвөн дэлбээт цэцэг нь энэ бүрэн бүтэн байдлыг төлөөлж, дөрвөн дэлбээ нь тэгш хэмтэй байрлалтай тул тэнцвэр, эв нэгдлийг илэрхийлдэг. Мандала нь төв цэг болон түүнийг хүрээлсэн хүрээ, дөрвөн зүгт чиглэсэн хаалга буюу хэсгүүдээс бүрддэг. Дөрвөн дэлбээт цэцэг нь энэхүү үндсэн бүтцийг маш тодорхой харуулдаг. Цэцгийн төв нь мандалын төв цэг, дэлбээ нь дөрвөн зүг, эсвэл хаалгыг төлөөлдөг. Дөрвөн дэлбээт цэцэг нь сэтгэцийн дөрвөн үндсэн үйл ажиллагаа (бодол, мэдрэмж, мэдрэхүй, зөн билэг)-г төлөөлж, эдгээрийн тэнцвэрийг илэрхийлж болно. Монголын эртний урлагт дөрвөн дэлбээт цэцэг нь дэлхий, орчлон, бурханы шашны бэлгэдлийг агуулсан байдаг.

Аливаа цэцэг нь байгалийн гоо үзэсгэлэн, бүтээлч байдал, амьдралын бэлгэддэг ч дөрвөн дэлбээт цэцэг нь Мандалагийн үндсэн элементүүдийн нэг гэдэг утгаараа Мандала нь төв болон түүнийг хүрээлсэн дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд энэ нь орчлон ертөнцийн бүтэц, сэтгэцийн бүрэн бүтэн байдлыг илэрхийлдэг.

Сэтгэцийн бүтэц бүхий тайлбар. Дөрвөн дэлбээт цэцэг нь босоо хэвтээ тэнхлэг, дугуй дүрс, болон дөрвөн зүгийн элементээс бүрдэхийн хувьд сэтгэцийн далд бүтэцтэй холбогдох бөгөөд энэ нь мандалын утгыг илэрхийлдэг. Сэтгэц дахь Мандала бүтэц нь тэгш хэм болон тэгш хэмт стетикийн ойлголтыг таатай хүлээн авах тархины чадварт нөлөөлдөг (McElroy 2020, 145).

Мандала нь сэтгэцийн бүтцийг олон талаар илэрхийлдэг бөгөөд энэ нь ялангуяа Карл Юнгийн сэтгэл зүйд чухал байр суурь эзэлдэг. Юнг Мандалаг хүний сэтгэцийн бүрэн бүтэн байдал, өөрийгөө нээх (индивидуаци) үйл явцын архетип бэлгэдэл гэж үзсэн ба Мандалагийн төв нь Юнгийн онолоор хүний сэтгэцийн төв болох “Өөрийн Би”-г бэлгэддэг. “Өөрийн Би” нь ухамсартай болон ухамсаргүй бүхнийг багтаасан сэтгэцийн бүрэн бүтэн байдлын илрэл. Мандалагийн төв рүү чиглэсэн хөдөлгөөн нь хувь хүний өөрийгөө нээх, төлөвших, бүрэн бүтэн болох хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг. Мандалын хүрээ нь эго болон ухамсартай сэтгэцийг төлөөлдөг бол төв нь ухамсаргүй сэтгэцийг илэрхийлдэг. Мандалагийн дөрвөн зүг буюу хаалга нь сэтгэцийн дөрвөн үндсэн үйл ажиллагаа болох бодол, мэдрэмж, мэдрэхүй, зөн билгийг төлөөлж болно (Jung 1944, 151). Энэхүү тэгш хэм нь сэтгэцийн эдгээр хэсгүүдийн хоорондын тэнцвэр, эв найрамдлыг илэрхийлэх ба Мандалаг бүтээх буюу бясалгах нь индивидуалцах (Individuation) үйл явцыг дэмждэг гэж үздэг. Энэ үйл явцад хувь хүн өөрийн ухамсаргүй талуудтайгаа нүүр тулж, тэдгээрийг ухамсартай болгож, улмаар сэтгэцийн бүрэн бүтэн байдалд хүрдэг. Мандалагийн төв рүү чиглэсэн бясалгал нь эго-г “Өөрийн Би” (Self)-д захирагдахыг

хэлдэг. Мандалаг арт терапи буюу урлагаар илаарьшуулах эмчилгээнд өргөнөөр ашигладаг ба мандал зурах, будах явцад өөрсдийн дотоод сэтгэлээ илэрхийлж, сэтгэцийн тэнцвэрт байдалд хүрэхэд тусалдаг. Мандалагийн тэгш хэмт хэлбэр нь тайвшруулах нөлөө үзүүлж, стресс, түгшүүрийг бууруулахад тусалдаг.

Юнг Мандалаг зөвхөн хувь хүний сэтгэцийн илэрхийлэл бус, харин “Хамтын ухамсаргүйн архетип хэлбэр” гэж үзсэн бөгөөд Мандала нь “хүн төрөлхтний нийтлэг сэтгэл зүйн бүтэц”-ийг илэрхийлдэг. Мандала нь сэтгэцийн бүтцийг олон талаар илэрхийлдэг бөгөөд ялангуяа Юнгийн сэтгэл зүйд хувь хүний өөрийгөө нээх үйл явц, сэтгэцийн бүрэн бүтэн байдал, ухамсаргүй сэтгэцийн илэрхийлэл зэрэг чухал утгыг агуулдагаараа онцлог байдаг. Дөрвөн дэлбээт цэцэг нь Мандала бүтэцтэй холбогдож байдгаараа мөн эдгээр шинж чанарыг агуулсан байж болно хэмээн үзэх үндэслэлтэй.



Source: drawing by Jung in his *Red Book of 2009*, released much later than his death in 1961.
The picture is a variation of celtic cross



Source: Mandala of Amitayus, Tibet, 19th century,
Rubin Museum of Art

*Зураг 5. Юнгийн функцийн дөрвөлөг бүтэц, Кельтийн загалмай ба Мандала
(April 2022 Transdisciplinary Journal of Engineering & Science)*

Хэлэлцүүлэг

Дөрвөн дэлбээт цэцгийн дүрслэл нь дөрвөн тэнхлэгээс бүтсэн монголын гоо зүйн тэгш зарчимтай мөн сэтгэлгээний цар хүрээ болон давтагдсан чанар геометрийн хэллэг гээд урлагийн сэтгэл зүйн онцлог, Мандала бүтэц гэх мэтээр олон улсад судлагдсан гол чухал дүрслэл. Энэхүү дүрслэлийг олон орны соёлд дүрсэлдэг боловч Монголоос олдсон археологийн олдворын үнэ цэнийг одоогоор сайн судлаагүй танигдаагүй байх магадлалтай тул энэхүү судалгааг хийж монгол нүүдэлчид мөн адил соёл урлагийн боловсрол ихтэй, дөрвөн тэнхлэгийн учир шалтгааныг мэддэг, тийм ч утгаараа язгууртандаа дагалдуулж алтаар урлаж оршуулгын зан үйлд хэрэглэдэг, мөн өдөр тутамдаа ч хэрэглэдэг байсан зан үйлийг таниулах зорилготой. Аливаа анхдагч хээ, дүрс нь өнгөц гоёчилсон, одоо цаг үеийн үйлдвэржсэн гоёчилж, гангалах имитаци бус харин үүсэл гарвал

нь “өөрөөсөө үүтгэгдсэн онцлог” бүхий байдаг бөгөөд эдгээр эрт үеийн суурь зарчмыг баримталж судалгаандаа ашиглах нь давуу талтай. Аливааг санаанаасаа зохиож үйлдэггүй байсан гэх эрт үеийн онцлогийг харгалзан үзэх нь тухайн үеийн соёлын контекстийг танихад нэмэртэй ба шашин болон урлагт эдгээр дүрслэл нь үргэлж оршин байдгийг онцлууштай. Дөрвөн дэлбээт цэцэг нь сэтгэцийн дөрвөн үндсэн үйл ажиллагаа (бодол, мэдрэмж, мэдрэхүй, зөн билэг)-г төлөөлж, эдгээрийн тэнцвэрийг илэрхийлж, монголын эртний урлагт дүрслэмжээ дөрвөн дэлбээт цэцэг бүхий болгож дэлхий, орчлон, бурханы шашны бэлгэдлийг агуулж, урлаг, соёлын бэлгэдэл болон хээний илэрхийлэл болон төлөөлөл архетиптай холбогддог. Энгийн дүрснээс энгийн бус зүйлсийг таньсан нүүдэлчдийн ухааныг дэлхий дахинд танин мэдүүлэх нь нэн чухал ба цаашид судалгааг өргөжүүлж гадаад хэлээр өргөжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Дөрвөн дэлбээт цэцэг нь эгэл нэгэн цэцгийн (хошоонгор) дүрслэмжээс үл хязгаарлагдах бөгөөд эрт үеийн анхдагч дүрс нь гоёл чимэглэлээс ангид өөрөө үүтгэгдэх шинж чанартай бөгөөд дугуй дүрс, төв цэг, анхдагч тэнхлэг, Мандала бүтэц гэх мэт хүн төрөлхтний сэтгэцийн анхдагч бүрдүүлбэрээс бүрдсэн үнэ цэн бүхий бэлгэдэлт дүрс, дүрслэмж юм.

Энэхүү дүрслэмжийн бэлгэдэл, шинж чанарыг таньсан нүүдэлчин өвөг дээдэс маань дөрвөн дэлбээт цэцгийн язгуурын шинж чанаруудыг дээдлэн үзэж амьдрал ахуйдаа хэрэглэж, нас барсан хүндээ хүндэтгэл үзүүлэн, хойд насыг урд наснаас эрхэмлэн үздэг байсан үзлээс үүдэн соёлын хэлбэрт хэрэглэж ирсэн нь хүннүгийн үеийн дөрвөн дэлбээт цэцэгтэй авсны чимэг бүхий археологийн олдвороос харагдаж байна.

Дөрвөн дэлбээт цэцгийн дүрслэмжийн хэллэг нь гоозүйн тэгш хэмт таатай байдлыг бүрдүүлдэг тэгш хэмийн тогтолцоотойгоороо онцлог.

Бид өвгөдийн үлдээсэн түүхийн ул мөрийг одоо үеийн байдлаар сэтгэж өнгөц дүгнэх эрхгүй ба эрт үеийн урлагт аливааг гоё сайхан болгох зорилготой чимэглэж дүрслээгүй байдаг онцлог нь эргэн дахин харах өнцгийг бидэнд олгож байна.

Хүн төрөлхтний гүнээс гүнд “хамтын ухамсаргүй- collective unconscious”-н түвшнээс гарч ирсэн дүр дүрслэл нь ийнхүү бидэнд өвлөгдөж ирэхдээ олон соёлын бүрдүүлбэр өв элемент болж байгаагаараа онцлог хэмээн дүгнэмээр байна.

Эдгээрээс бид урлаг дахь ухамсарт байдал буюу эдүгээчилсэн байдлаас урьтаж ухамсаргүй байдлын тухай ярих нь илүү гүн гүнзгий судлах, эх дүрсийг танин мэдэх нэгэн гарц гаргалгаа болж байна. Урлаг дахь ухамсаргүй байдлыг судлах нь урлагийн бүтээлийг илүү гүн гүнзгий судлах, эх дүрсийг танин мэдэхэд чухал ач холбогдолтой арга зүй мөн бөгөөд урлагийн бүтээлийн цаана нуугдаж буй утга санааг нээж, хүн төрөлхтний нийтлэг туршлагыг ойлгоход тусалдаг. Мөн энэхүү хандлагыг болгоомжтой, ухамсартай хэрэгжүүлэх нь чухал бөгөөд урлагийн бүтээлийн бүх талыг харгалзан үзэх шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Дулам, С. 2011, *Монгол бэлгэдэлзүй III Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар.

Нямбуу, Х. 1998. *Халхын зарим нутгийн хээ угалзны зүйлээс*. Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Dawn Whitehand. 2009. "Pattern that Connect." *Leonardo* Vol.42 (1): 10-15. <https://doi.org/10.1162/leon.2009.42.1.10>.

Gerhard Wagner. 2011. *Visionary Art and Collective Consciousness: A Guide to the Inner Reaches*.

Jung C.G. 1944. *Psychology and Alchemy*. https://www.jungiananalysts.org.uk/wp-content/uploads/2018/07/C.-G.-Jung-Collected-Works-Volume-12_-Psychology-and-Alchemy.pdf.

Jung C.G. 1964. *Man and Symbols*. <https://antilogicalism.com/wp-content/uploads/2017/07/man-and-his-symbols.pdf>.

McElroy D.R. 2020. *Signs and Symbols of the world* https://www.google.mn/books/edition/Signs_Symbols_of_the_World/TYLiDwAAQBAJ?hl=en&gbpv=1&dq=The+Illustrated+Book+of+Signs+and+Symbols+-+Softcover+Bruce-Mitford&printsec=frontcover.

Mercia Eliade. 1957. *The Sacred and the Profane: The Nature of Religion*. https://monoskop.org/images/b/b1/Eliade_Mircea_The_Sacred_and_The_profane_1963.pdf.